

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

**СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЗАХ
ЗЭЭЛИЙН ДАРААХ ТАНДАЛТ, ЭМИЙН СОНГОЛТЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН М.ХИШИГЖАРГАЛЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
1	2	3	4	5	6	7		
ЗОРИЛТ 1. “ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ, БОДЛОГЫН НЭГДСЭН ЗОХИЦУУЛАЛТ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД								
1.	Арга хэмжээ 1.1. Эмийн эмнэлзүйн туршилтын үе шат, тавигдах шаардлага, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага, гэрээний загвар, хяналт тавих журам, лабораторийн оношилгооны хэрэгслийн туршилт судалгаа хийх журмыг батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан журам	-	Эрүүл мэндийн сайдын тушаалаар журам батлуулсан байна.	Эмийн эмнэлзүйн туршилтын үе шат, тавигдах шаардлага, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага, гэрээний загвар, хяналт тавих журам, лабораторийн оношилгооны хэрэгслийн туршилт судалгаа хийх журмыг боловсруулах аэлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/146 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулж, журмын төслийг боловсруулж байна.	2025.04.01-2025.09.30 /хугацаа болоогүй/	30% 100 хувь хугацаа болоогүй	
2.	Арга хэмжээ 1.2. Зах зээл дэх тусгай зөвшөөрөл, бүртгэл, зар	Ажлын төлөвлөгөө Судалгааны үр дүн	-	Ажлын төлөвлөгөөний дагуу судалгааны үр	Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн “Хууль бус эмийн худалдааг хянах болон эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх тухай” 03			

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
	сурталчилгааны зөвшөөрөлгүйгээр худалдаалагдаж буй эмийн судалгааг хийх			дүн гарсан байна..	дугаар албан даалгаврыг батлуулж, чиг үүргийн дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт зах зээлд худалдан борлуулагдаж байгаа тусгай зөвшөөрөлгүй, хууль бус зар сурталчилгаа явуулж буй байгууллага, хувь хүн болоод Улсын бүртгэлд бүртгэлгүй эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний тандалт судалгааг 2025 оны 7 сарын 04-ны өдөр судалдааны үр дүнг танилцуулах, Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирал нарт цахим жор бичилт, олголтыг эрчимжүүлэх, эмийн зохистой хэрэглээний талаар иргэдэд чиглэсэн мэдээ, мэдээлэл сурталчилгааг эрчимжүүлэхийг үүрэг болгосон.	2025.03.01 - 2025.06.31	80 хувь
ЗОРИЛТ 2. “ЗАХ ЗЭЭЛИЙН ДАРААХ ТАНДАЛТ СУДАЛГАА, БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Арга хэмжээ 2.2. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны ажиллах журам болон Эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх, үнэлэх, тайлагнах журмыг хүчингүй болгох	Журам хүчингүй болсон байна.	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/414 дугаар тушаал, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эрүүл мэндийн	Дээрх тушаалууд хүчингүй болсон байна.	Эрүүл мэндийн сайдын 2025 оны 4 дүгээр сарын 04-ны өдрийн “Тушаал хүчингүй болгох тухай” А/110 дугаар тушаалаар 2019 оны “Журам шинэчлэн батлах тухай” (Эмийн эмчилгээг зохицуулах хорооны ажиллах журам) А/414 дүгээр тушаалыг хүчингүй болгосон. Эрүүл мэндийн сайдын 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн “Тушаал хүчингүй болгох тухай” А/152 дугаар тушаалаар	2025.03.01 - 2025.05.01	100 хувь

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
			сайдын 2023 оны А/67 дугаар тушаал		2023 оны "Журам шинэчлэн батлах тухай" (Эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх, үнэлэх, тайлагнах журам) А/67 дугаар тушаалыг хүчингүй болгосон.		
ЗОРИЛТ 3. "ЭМИЙН СОНГОЛТЫН БОДЛОГО, НЭГДСЭН ЗОХИЦУУЛАЛТ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Арга хэмжээ 3.1. Нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг байгууллагуудын хэрэгцээ шаардлага, саналд үндэслэн сонгож, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах	Худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийг нэг эх үүсвэр, олон улсын байгууллага эсвэл үйлдвэрлэгч эс худалдан авах жагсаалт батлагдсан байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль 47 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны 42 дугаар тогтоол	Эрүүл мэндийн сайдын тушаал батлагдсан байна.	Нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээнд түгээмэл хэрэглэгддэг, төрөөс төлбөрийг нь хариуцах удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардагдах эмгэгийн болон хөнгөвчлөх, иргэдэд эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр олгох эм байх зэргийг харгалзан үзэж, нэр төрөл сонгоход хамтран ажиллаж байна.	2025.12.31 /хугацаа болоогүй/	100 хувь 30%
2.	Арга хэмжээ 3.2. Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг шинэчлэн батлуулах	Жагсаалт гарсан байна.	Зайлшгүй шаардлагатай эмийн 10 дугаар жагсаалт	Зайлшгүй шаардлагатай эмийн 11 дүгээр жагсаалт батлагдсан байна.	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т заасны дагуу Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн "Зайлшгүй шаардлагатай эмийн XI, хүүхдийн зайлшгүй шаардлагатай эмийн IV жагсаалтын төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай" А/79 дүгээр тушаал батлагдсан. Зайлшгүй эмийн жагсаалтыг боловсруулах шалгуурыг баталсан ба Эмийн эмчилгээний хороо, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн	2025.02.10-2025.09.30 /хугацаа болоогүй/	70 хувь 30%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					салбар зөвлөлүүдээс саналуудыг авч ажиллаж байна.		
ЗОРИЛТ 4. “ЭМИЙН ХЭРЭГЛЭЭ, ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ БОДЛОГО, НЭГДСЭН ЗОХИЦУУЛАЛТ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Арга хэмжээ 4.1. Эмийн зөв зохистой хэрэглээ, эмийн зохицуулалтын үйл ажиллагааны талаар иргэдэд чиглэсэн мэдээ, мэдээлэл, контент хийх	Мэдээ, контентийн хуваарь, тоо	-	Эрүүл мэндийн яам, ЭЭХХЗГ, бусад харьяа байгууллагуудын цахим суваг болон сайт, мэдээллийн хэрэгслээр мэдээ, контент хуваарийн дагуу цацагдсан байна.	Эмийн жор болон эмийн зөв зохистой хэрэглээг иргэд, олон нийтэд сурталчилан таниулах зорилго бүхий “ЗӨВ ЖОР-ЗӨВ ЭМЧИЛГЭЭ” аян, Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагаа, Нэг эх үүсвэрийн эмийн бодлогын талаарх контент мэдээллийг 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн. Аяны лого, брэндinгийг мэргэжлийн байгууллагаар бүтээлгэж, цахим орчинд болон зар сурталчилгааны чиглэлээр хийж хэрэгжүүлэх нийт 7 ажил, арга хэмжээг төлөвлөн, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хуваарийн дагуу хэрэгжүүлсэн. Нийт 65 контент мэдээ, мэдээлэл бэлтгэн Эрүүл мэндийн яамны цахим хуудас болон төв орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын нийт 43 цахим хуудсуудад нийтэлсэн нь давхардсан тоогоор 5,912,740 цахим хэрэглэгчдэд хүрсэн байна. Үүнд: Зорилтот видео бичлэг 5, Богино видео бичлэг 25, зурган постер 34, зар сурталчилгааны 2 төрлийн зорилтот шторк бэлтгэн: 9 телевизийн зарын цагуудаар нийт 14 хоног, Улаанбаатар хотын нийтийн орон	2025.01.01 – 2025.04.01	100 хувь

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					сууцны лифтэнд байрлах 1,640 зар сурталчилгааны лед дэлгэцэд 14 хоног, 10 төрлийн аудио шторк бэлтгэн: богино долгионы 10 фм радиогийн онцлох цагуудад 15 хоног байршуулж өдөрт 10 удаагийн давтамжтай нийт 1200 цацалт хийсэн. энэ нь давхардсан тоогоор 5.0 орчим сая хүнд хүрсэн байна. Мөн Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн “Хууль бус эмийн худалдааг хянах болон эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх тухай” 03 дугаар албан даалгаврыг батлуулж Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирал нарт үүрэг хүргүүлсэн.		
ЗОРИЛТ 5. “ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН БУСАД ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, БАЙГУУЛЛАГЫН БОЛОН НЭГЖИЙН ДОТООД АЖИЛД ОРОЛЦОХ, УДИРДЛАГААС ХУУЛЬ ЁСНЫ ХҮРЭЭНД ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫГ БИЕЛҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	Арга хэмжээ 5.1. Ажлын товч тайланг газар, хэлтэст 7 хоногт 1 удаа, жилд 52 удаа, СТГ-ын хуваарийн дагуу хууль тогтоомжийн	Тайлангийн тоо	-	Ажлын товч тайланг газар, хэлтэст 7 хоногт 1 удаа буюу - 24 удаа, СТГ-ын хуваарийн дагуу хууль тогтоомжийн	Ажлын товч тайланг газар, хэлтэст 7 хоногт 1 удаа буюу 24 удаа, СТГ-ын хуваарийн дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг 2 удаа, УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороонд Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга	2025.01.01 – 2025.12.31	100 хувь

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	хэрэгжилтийн тайлан, хэлтсийн даргын гүйцэтгэлийн тайлан, дотоод меморандум, газрын цагийн бүртгэлийн мэдээг нэгтгэх болон гүйцэтгэлийн тайланг цаг хугацаанд нь өгсөн байна.			хэрэгжилтийн тайлан - 1 удаа	хэмжээний тухай Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 38 дугаар тогтоолын тайлан, УИХ-ын гишүүн Б.Чинбүрэнд Эмийн аюулгүй байдалтай холбоотой 827 хуудас тайланг тус тус цаг хугацаанд нь өгч ажилласан.		
2	Арга хэмжээ 5.2. Байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж, ажлын хэсэгт орж ажиллана.	Ажлын хэсэгт орсон тушаалын тоо	-	Эрүүл мэндийн сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэгт орж ажилласан байна.	2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Эрүүл мэндийн сайдын "Ажлын хэсэг байгуулах тухай" А/53 дугаар тушаалын дагуу "Эрүүл мэндийн сайдын нэрэмжит спортын 6 төрөлт арга хэмжээ"-ний зохион байгуулалтад орж ажилласан. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар "Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдах "Сувилагч тандаа баярлалаа-2025" зөвлөгөөн"-ий зохион байгуулалтад орж ажилласан.	2025.01.01 - 2025.12.31	100 хувь
Нэмэлт ажил							
1	Уналт, таталт өвчний үед хэрэглэх эмийн сонголт, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	Бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулсан байна.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний жагсаалт, эм олгох үйл ажиллагааг зохицуулах журам батлах тухай" А/407 дугаар тушаалд "Уналт, таталт өвчний үед хэрэглэх эмийн нөөцийг харгалзан	2025.01.01 - 2025.04.01	100 хувь

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					нийтийн үйлчилгээтэй эмийн сангаас олгож болно”, “...олон улсын эмнэлзүйн удирдамжид зөвлөсөн эмчилгээний практикт хэрэглэгдэж буй эмийн мэдээлэлд үндэслэн...”, шалгуурын хэсэгт “хүүхэд” гэснийг “бүх тохиолдолд”, “Бүх төрлийн хорт хавдрын дараах бай болон хөнгөвчлөх эмчилгээ” гэж тус тус нэмэлт өөрчлөлт оруулж 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/06 дугаар тушаалыг батлуулсан. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 4/108 дугаартай “Санал хүргүүлэх тухай” албан бичгээр Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 06 дугаар тогтоол “Төрөөс төлбөрийг нь хариуцах зарим өвчин эмгэг, түүний эмийн жагсаалт, хэлбэр, тун” жагсаалтад уналт, таталт, эпилепси өвчний үед хэрэглэх 15 нэр төрлийн эм, хорт хавдрын эмчилгээний 3 нэр төрлийн, сэтгэц зан үйлийн эмгэгийн 1 нэрийн эм оруулахаар санал хүргүүлсэн. ЭМДҮЗ-ийн 06-р тогтоолд уналт таталтын 16 нэрийн эм байсан бол тус тогтоолыг шинэчилж, 2025 оны 04 дугаар тогтоолоор 31 нэр, төрөл болж нэмэгдсэн. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 2/1500 дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичиг мөн		


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					Эрүүл мэндийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн “Хууль бус эмийн худалдааг хянах болон эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх тухай” 03 дугаар албан даалгавраар Зарим цөөн хэрэглээтэй, эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай, тасалдал үүсч байгаа буюу шалтгаанаар Эмийн зөвлөлийн шийдвэрээр нэг удаагийн импортын мэдүүлэг олгож байгаа эмийг зайлшгүй бүртгэлжүүлэх чиглэлээр уулзалт зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд үйлдвэрлэгчдэд хүсэлт илгээх зэргээр ханган нийлүүлэх байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах талаар чиглэлийг хүргүүлсэн.		
2	ЭМД-ын сангаас хөнгөлөлттэй олгох эмийн жагсаалтыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх	Шийдвэрлэсэн асуудлын тоо	-	1	2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдөр болон 4 дүгээр сарын 02-ны өдөр ЭМДЕГ, ЭЭХХЗГ-ын холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, 48 нэрийн эмийн олгох нөхцөлийн асуудлыг шийдвэрлэж, Урсодезоксихилийн хүчил эмийн олгох нөхцөлийн талаар Эм судлалын салбар зөвлөлийн 2 удаагийн хурлаар хэлэлцүүлж, ЭМЯ-ны дэргэдэх Эм зүй, эм судлалын мэргэжлийн салбар зөвлөлд 2025 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 4-3/1571 дугаартай албан бичиг хүргүүлэн санал авч Эмийн зөвлөл, Эм судлалын салбар зөвлөлийн хурлуудаар хэлэлцүүлсэн ба дахин Эмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.	2025.02.01 – 2025.10.01	90 хувь

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Эмийн зохицуулалтын үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн орчин судлах	Эмийн зохицуулалттай холбоотой семинар, сургалт, хуралд оролцсон байна. Холбогдох хууль эрх зүйн орчинг судалсан байна.	-	Сургалт, хуралд оролцсон байна. Холбогдох хууль эрх зүйн орчинг судалсан тайлан	NICE-аас зохион байгуулсан “Health Technology Assessment” сургалтад оролцож, сертификат авсан. ДЭМБ-аас зохион байгуулсан “WHO-ADB Joint Training Workshop on WHO Guideline on Implementing Quality Management System for Mongolia” сургалтад оролцож, сертификат авсан. Эмийн зохицуулалтын үйл ажиллагаа буюу эмийн олгох нөхцөлийн талаар олон улсын эрх зүйн орчин, баримт бичгийг судалсан. Үүнд: - АНУ-ын Food and Drug Administration (FDA)-с эрхлэн гаргадаг “Over-the-Counter /OTC/ Drug Monograph”, - Их Британи Улсын British Medical Association (BMA), Royal Pharmaceutical Society /RPS/ байгууллагаас хамтран гаргадаг “British National Formulary”, - Австрали Улсын Therapeutic Goods Administration (TGA)-с эрхлэн гаргадаг “Poisons Standart” баримт бичиг, бусад улсын баримт бичгүүд Эмнэлзүйн зохистой дадлын талаар WHO-Guidelines for good clinical practice (GCP) for trials on pharmaceutical products -1995, WHO-Handbook for good clinical research practice (GCP) – 2005, ICH – Guideline for good clinical	2025.01.01 – 2025.12.31	100 хувь

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					practice E6(R2) – 2016 зэрэг бичиг баримтад харьцуулсан судалгааг хийсэн.		
2.	Арга хэмжээ 2. Худалдан авах ажиллагааны АЗ сургалтанд хамрагдаж, гэрчилгээ авах	АЗ сертификат	-	АЗ сертификат	Худалдан авах ажиллагааны АЗ сургалтанд бүртгүүлсэн.	2025.04.01 – 2025.09.30	70 хувь

Мэргэжилтэн
(Албан тушаал)

ТАЙЛАН ГАРГАСАН:

 /М.Хишигжаргал/
 (Нэр, гарын үсэг)

2025.06.10
(Огноо)